



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/199

Эрдэнэт


Программ хийхэд хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "а", 29.2, Засгийн газрын 322 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны ээлжит 5 дугаар хуралдааны 05/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Тэргүүлэгчдийн тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тооцох цахим программыг хийлгэх ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс /н.Жанболат/-т даалгасугай.

2. Дээрх ажилд шаардагдах 8.000.000 /найман сая/ төгрөгийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тооцох цахим программ хийлгэх зардлыг Засаг даргын бусад зардал болох төсөл хөтөлбөрийн зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ